



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (346)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай*
- *Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны дөрөвдүгээр сарын 6

№13 (346)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

153.	Жөн Мон Гү-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 25	254
154.	Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 26	254
155.	Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 29	254
156.	Дагвын Бадамд хошууч генерал цол хүртээх тухай	Дугаар 35	255
157.	Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээх тухай	Дугаар 36	255
158.	Журам батлах тухай	Дугаар 37	255

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

159.	Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай	Дугаар 34	256
160.	"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай	Дугаар 36	258
161.	Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 37	269
162.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 38	271
163.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 39	271
164.	Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг тогтоох тухай	Дугаар 40	271
165.	Хөрөнгө гаргах тухай	Дугаар 41	272
166.	Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 42	272

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 25

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Жөн Мон Гү-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын эдийн засаг, соёл, Гү-г "Алтан гадас" одонгоор шагнасуугай. боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын иргэн, "Хендэ-Киа" группийн эзэн Жөн Мон

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 26

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцааг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ерөнхийлөгч Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнасуугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 29

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтыг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсуугай.

1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд "Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга", "Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга" гэж шинээр нэмэх.

2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаа "Төрийн хянан шалгах хорооны ерөнхий нарийн бичгийн дарга" гэснийг "Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч", "Хилийн цэргийг удирдах газрын дарга" гэснийг "Хил хамгаалах ерөнхий газрын дарга", "Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн захирал" гэснийг "Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн захирал", "Монголын залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга" гэснийг "Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч" гэж тус тус

өөрчлөх.

Хоёр. Мөн зарлигийн 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсуугай.

1. Журмын "Нийтлэг үндэслэл" бүлэгт "9.Зөвлөл нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад жил бүр тайлагнаж байна" гэж, "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлэгт "6.Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийн тэргүүн түшмэл байна." гэж, "Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай" бүлэгт "4.Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль, бусад хууль, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хөтөлбөрүүдэд заасны дагуу эдгээр хууль, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Зөвлөлийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ" гэж тус тус шинээр нэмэх.

2. Журмын "Нийтлэг үндэслэл" бүлгийн 7-д "албан бичгийн хэвлэмэл хуудас" гэсний дараа "тамга" гэж, "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлгийн 2 дахь

хэсгийн 4-т "Шаардлагатай гэж үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарим хэсгийг Зөвлөлийн мэдэлд төвлөрүүлж, улсын хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хөнгөрүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнд зарцуулах," гэж, мөн бүлгийн 4 дэх хэсгийн "в"-д "Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих" гэсний дараа "холбогдох асуудлаар захирамж, албан даалгавар гаргах," гэж тус тус нэмэх,

3.Журмын "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлгийн 4 дэх хэсгийн "б" -г "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 1-д заасны дагуу Зөвлөлийн ажлын албаны бүтэц, нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний санхүүжилтийн хэмжээг тогтоож, эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, байгууллагуудын орон тоо, цалингийн сангийн хязгаарт багтаан орон тоог нь зохицуулах, албаны дүрэм, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, албаны дарга, ажилтныг томилох, чөлөөлөх" гэж; "Зөвлөлийн үйл ажиллагааны

санхүүжилтийн тухай" бүлгийн 3-ыг "Зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг Засгийн газрын Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн гишүүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн багцад жил бүр бие даалган төлөвлөж, санхүүжүүлнэ. Хууль зүй, дотоод хэргийн яам Зөвлөлийг ажлын байраар хангаж, ажлаа хэвийн явуулах бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ" гэж; "Аймаг, нийслэл, сум дүүргийн салбар зөвлөл" бүлгийн 4-ийг "Орон нутгийн салбар зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгайлан тусган санхүүжүүлж байна. Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг тухайн ИТХ, Засаг даргын Тамгын газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ" гэж тус тус өөрчлөх.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 35

Төрийн ордон. Улаанбаатар хот

### Дагвын Бадамд хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Ар талын газрын дарга Дагвын Бадамд

хошууч генерал цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 36

Төрийн ордон. Улаанбаатар хот

### Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Энхийг сахиулах ажиллагааны газрын дарга

Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 37

Төрийн ордон. Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэргийн дээд цол олгох ёслолын журмыг

хавсралтын ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны  
3 дугаар сарын 15-ны өдрийн 37 дугаар  
зарлигийн хавсралт

## ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ЕСЛОЛЫН ЖУРАМ

### НЭГ. Ерөнхий заалт

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээсн цэргийн дээд цолыг олгохдоо энэ журмыг баримтлана.

2. Цэргийн дээд цол олгох ёслолыг Төрийн ордны "Соёмбо" танхимд гүйцэтгэнэ.

3. Цэргийн дээд цолны батламж бичиг,

### Хоёр. Ёслол үйлдэх журам

5. Цэргийн дээд цол хүртэж буй офицер цэргийн ёслолын дүрэмт хувцастай цол олгох ёслол үйлдэх танхимд хүрэлцэн ирнэ.

6. Цэргийн дээд цол хүртээх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан уншина.

7. Зарлиг уншсаны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч генерал цол хүртээсэн батламж

мөрдэсийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч гардуулна.

4. Цэргийн дээд цол олгох ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөх, цэргийн дээд цол хүртэгчийн шадар захирагч /дарга/ байлцана.

бичгийг, генерал цолны мөрдэсийн хамт цэргийн дээд цол хүртэгчид гардуулж, баяр хүргэнэ.

8. Цэргийн дээд цол хүртэгч Монгол Улсын Ерөнхийлөгчид цэргийн дүрэмд заасны дагуу талархал илэрхийлнэ.

9. Цэргийн дээд цол хүртэгч генералын ёслолын дүрэмт хувцсаа өмсч, цэргийн дээд цол хүртсэн тухайгаа Ерөнхийлөгчид илтгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17, 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бий болсон цагийн байдалтай уялдуулан гамшигын хор уршгийг арилгах, голомт тэлэхээс урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшигтай тэмцэх комиссын ажиллах журмыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо,

Комиссын ажиллах журам,  
бүрэлдэхүүн батлах тухай

ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтыг 2 дугаар хавсралт ёсоор өөрчилж, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 166 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

Засгийн газрын 2004 оны 34 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гамшигтай тэмцэх комисс /цаашид комисс гэх/-оос хэрэгжүүлж буй гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааг зохицуулахад энэхүү дүрмийг зорилго оршино.

2. Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

3. Комиссын үйл ажиллагаа нь Ерөнхий сайдын шийдвэрээр эхэлж гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч дуусган үр дүнг Ерөнхий сайдад илтгэснээр дуусгавар болно.

4. Комиссыг эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон сайд даргална.

5. Комисс нь гамшгийн цагийн байдалтай холбоотой асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар шийдвэр гаргана. Шийдвэр нь протоколын хэлбэртэй байна.

Хоёр. Комиссын бүрэн эрх

6. Комисс дараахь үүргийг гүйцэтгэнэ:

6.1. Гамшгийн цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээ, ажиллах техник хэрэгсэл, материалын болон мөнгөн хөрөнгийн асуудлаар санал, төсөл боловсруулж Ерөнхий сайдад танилцуулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

6.2. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах;

6.3. Гамшгийн цагийн байдлын талаар төр, засгийн удирдлагад шуурхай мэдээлэх, тэдний өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.

7. Комисс дараахь эрхтэй байна:

7.1. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, иргэдийг зохих хууль тогтоомжийн дагуу татан оролцуулах;

7.2. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгааг гаргуулан авах;

7.3. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах,

илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

Гурав. Комиссын чиг үүрэг

8. Комисс нь гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулахдаа дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. Гамшгийн цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

8.2. Хорио цээрийн дэглэмийг сахиулах, харуул, хамгаалалтын ажлыг зохион байгуулах;

8.3. Гамшгийн голомтод ажиллах бүрэлдэхүүнийг тогтоож, дэд бүтцийн асуудлыг зохих байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж, зохицуулах;

8.4. Гамшгийн голомт, түүний орчинд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

8.5. Нэрвэгдэгсдэд туслах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, зохицуулах;

8.6. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зохих журмын дагуу тээврийн хэрэгсэл, ажиллах хүчийг дайчлан гаргах ажлыг зохион байгуулан зохицуулах, байршуулах;

8.7. Шаардлагатай гэж үзвэл гамшгийн голомттой харилцах дундын цэгийг байгуулах, гамшгийн голомт болон түүний орчны бүсэд ажиллаж байгаа хүмүүс, автомашин, техникийн хангалт, үйлчилгээний асуудлыг шийдвэрлэж зохион байгуулах, зохицуулах.

Дөрөв. Бусад

9. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг Гамшгаас хамгаалах ерөнхий газраас гаргасан тооцоог үндэслэн гамшгийн эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

Засгийн газрын 2004 оны 34 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	- Эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон сайд
Орлогч дарга	- Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга
Гишүүд	- Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын албаны дарга; - Эрүүл мэндийн улсын албаны дарга; - Хүнс, хөдөө аж ахуйн улсын албаны дарга; - Дэд бүтцийн улсын албаны дарга; - Хэв журам сахиулах улсын албаны дарга; - Сурталчилгаа, мэдээллийн улсын албаны дарга; - Цацрагийн аюулаас хамгаалах улсын албаны дарга; - Мэргэжлийн хяналтын улсын албаны дарга; - Газрын улсын албаны дарга; - Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Нийслэлийн Засаг даргын орлогч; - Нутаг дэвсгэр дээр нь гамшиг болсон аймаг, сумын Засаг дарга;
Нарийн бичгийн дарга	- Гамшгаас хамгаалах ерөнхий газрын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар  
хот

### "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж, хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тогтоолоор батлагдсан журмын дагуу тендерийг зохион байгуулж явуулах, тендэрт ялсан стратегийн хөрөнгө оруулагчтай тендерийн баримт бичигт заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож менежментийн гэрээ байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгасугай.

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

2. Тендерийн зар мэдээг дотоод, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж сурталчлах, холбогдох хууль тогтоомж болон энэ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2004 оны 36 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний (казино оролцуулан) гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг

менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчдыг олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалт (цаашид "тендер" гэх)-д Монгол Улсын Засгийн газар урьж байна.

Тендерийг Засгийн газрын энэхүү тогтоолоор батлагдсан "Уралдаант шалгаруулалт (тендер)-ын журам"-д тусгагдсан болзол, нөхцөлийн



дагуу Үйлдвэр, худалдааны яамнаас зохион байгуулж явуулна.

### "Замын Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн байршил

Чөлөөт бүс нь Улаанбаатараас 780 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 230 км, БНХАУ-ын Эрээн хотоос 8 км-т орших Монгол Улсын өмнөд хилийн байнгын ажиллагаатай боомт Замын-Үүд тосгоны нутаг дэвсгэрт байрлана.

### "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн тухай

"Замын-Үүд" нь 47.8 мянган га нутаг дэвсгэртэй, 7000 орчим хүн амтай Монгол Улсын урд хил дээр оршдог хилийн боомт тосгон болно. Замын-Үүдээр олон улсын галт тэрэг дайран өнгөрдөг бөгөөд, ачаа бараа, шингэн түлш шилжүүлэн ачих орчин үеийн сэлгээний станцтай. Уг тосгонд өдөрт 2000 хүн, 300 автомашин нэвтрэх хүчин чадалтай хилийн иж бүрэн цогцолбор, тоон системийн сансарын холбоо болон шилэн кабель, авто болон төмөр зам, холбоо мэдээлэл, эрчим хүчний хангамж зэрэг дэд бүтэц харьцангуй сайн бүрдэж байгаа. Монгол Улсын эдийн засгийг БНХАУ, улмаар Азийн орнуудтай холбосон тээвэр-газар зүйн тохиромжтой байрлалтай, манай орны гадаад худалдаа, зорчигч тээврийн зонхилох хэсгийг нэвтрүүлдэг гол боомт тул чөлөөт бүс байгуулах үндсэн нөхцөл бүрдсэн гэж үзэж болно.

### Үйл ажиллагааны үндсэн чиглэл

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуульд "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс нь үйлдвэрлэл, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний гэсэн үндсэн 3 хэлбэртэй байхаар тусгагдсан. Хэлбэр тус бүрт үйлдвэрлэл, үйлчилгээний дараахь чиглэлийг баримталж ажиллах юм. Үүнд:

#### 1. Үйлдвэрлэлийн хэсэгт

Усны хэрэглээ багатай, байгаль орчинд халгүй, ялангуяа хөрсний эвдрэлд нөлөөлөхгүй үйлдвэрлэлийг байгуулж хөгжүүлнэ. Тухайлбал гадаадын пүүс, компанийн захиалгаар аудио, видео тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, цахим төхөөрөмж угсрах үйлдвэрүүд, экспортын чиг баримжаатай оёмол, сүлжмэл болон модон эдлэл, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэл гэх мэт.

#### 2. Худалдааны хэсэгт

Биржийн арилжаа, үзэсгэлэн-худалдаа зонхилон эрхлэх худалдааны цогцолбор байгуулах бөгөөд барааг ангилж савлах, сав баглаа, боодлыг сайжруулах нэмэгдэл үйлчилгээг үзүүлнэ. Худалдааны хэсэгт банк, санхүүгийн байгууллага, холбоо мэдээллийн төвийг байгуулах.

#### 3. Аялал жуулчлал-үйлчилгээний хэсэгт

Аялал жуулчлалын бааз, зочид буудал, ресторан, кафе, түргэн хоолны газар, мини гольфын талбай, морин уралдааны талбай, тэмээн поло, казино байгуулах, шоу бизнесийг хөгжүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлэх.

### Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Тендерт оролцохыг хүссэн сонирхогч "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний хэлбэрүүдийг иж бүрнээр байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэхээр тендерт саналаа ирүүлж болно. Стратегийн хөрөнгө оруулагч нь эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх мастер төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт дэд бүтцийн барилга, байгууламжийг барьж байгуулах үүрэг хүлээнэ.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй этгээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг англи эсхүл монгол хэл дээр дараахь материалын хамт Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ. Үүнд:

#### 1. Өргөдөл;

2. Зохих журмын дагуу үйлдэж, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;

3. Буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй 1000 / нэг мянган/ ам долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт;

4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг баталгаажуулсан итгэмжлэг;

5. Өргөдөл гаргагчийн тухай танилцуулга. Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай:

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлж байгаа компанийн албан ёсны нэр, хаяг



болон үйл ажиллагааны талаархи танилцуулга /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/.

Эдийн засгийн чөлөөт бүсийн болон тухайн бизнесийн үйл ажиллагааны талаар туршлага хуримтлуулсныг батлах мэдэгдэл.

Тендерт оролцож байгаа компанийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд.

Санхүүгийн сүүлийн 3 жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл буюу нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан сүүлийн жилийн тайлан /энэхүү мэдээллийг консорциумд оролцож байгаа компани тус бүрээр гаргаж өгнө/.

Өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн жагсаалт / консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/.

Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн баталгаа.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Үйлдвэр, худалдааны яамны [www.mit.pmis.gov.mn](http://www.mit.pmis.gov.mn) вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээнд бичигдсэн хаягаар авч болно.

Тендерийн хураамжийг Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны дараахь дансанд төлнө.

Банкны нэр :	Монгол Улсын Монгол банк
SWIFT код :	BOMUMNUB
Дансны нэр :	Үйлдвэр, худалдааны яам
Дансны дугаар :	3309001
Монгол банкны харилцагч банк :	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код :	FRNYUS33
Дансны нэр :	Монгол банк
Дансны дугаар :	021088506

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тохиолдолд түүний төлөөлөх

эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдлийг 2004 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.

#### Урьдчилан шалгаруулалтын шалгуур

Өргөдөл гаргагч нь тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциум байхын зэрэгцээ дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Эдийн засгийн чөлөөт бүсийн менежментийн арга барил эзэмшсэн, чөлөөт бүсэд тухайн бизнесийн чиглэлээр тав /5/-аас доошгүй жил ажиллаж тодорхой туршлага хуримтлуулсан байх;

2. 150.0 /нэг зуун тавин/ сая ам.доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;

3. Санхүүгийн байдал нь тогтвортой; үйл ажиллагааны туршлагатай байх /үүнийг аудитаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/.

#### Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдэгдэх

Үйлдвэр, худалдааны яам өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 /арван/ өдөрт багтаан урьдчилан шалгаруулалтын шалгуурыг ханган тендерт оролцох болж, тендерийн баримт бичгүүдийг авах эрхтэй болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг бичгээр үйлдэн буухиа шуудан, баталгаат шуудан, факс буюу электрон шуудангаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангасан оролцогчдод тендерийн баримт бичгүүдийг мэдэгдлийн хамт буухиа шуудангаар хүргүүлнэ.

#### Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичиг гэдэгт дараахь иж бүрдлийг ойлгоно:

1. Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам;
2. Ерөнхий мэдээлэл;

3. Менежментийн гэрээний төслийн иж бүрдэл.

Тендерийн зорилго

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагч Засгийн газраас дэвшүүлсэн дор дурдсан зорилтыг тусгасан бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орчин үеийн чөлөөт бүсийн жишигт хүргэж Монгол Улсын төвийн бүсийг хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүхий бүс болгоход хувь нэмэр оруулах замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд нөлөөлөх.

2. Дэлхийн өндөр хөгжилтэй үйлдвэрлэл, технологийн чиглэлээр тэргүүлэгч орнуудтай худалдаа, аялал жуулчлалын болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орос, хятадын хоёр том зах зээлийг холбосон худалдааны томоохон гүүр болгох, улмаар Зүүн Өмнөд Азийн орнуудын зах зээлд нэвтрэх гол гарцын нэг болгох.

3. Экспорт, импортын зохистой харьцааг хадгалах, гадаад худалдааг үр ашигтай хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх замаар улс орны зах зээлийн хангамж нийлүүлэлтийг сайжруулах.

Тендерийн ажиллагаа

Тендерт оролцогчид нь тендерийн саналаа тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.

Тендерийн дэнчин нь 500000 /таван зуун мянган/ ам.доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламж байна. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны 3309001 дугаартай валютын дансанд төлнө.

Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг /дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заасан/ тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоо/ өдөрт багтаан бүрэн буцаан олгоно.

Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн дэнчинг үйл ажиллагаагаа эхэлсний дараа түүний хүсэлтийн дагуу ажлын 7 (долоо) өдөрт багтаан Монгол Улсын аль нэг арилжааны банкинд нээсэн валютын харилцах дансанд нь шилжүүлнэ.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон эдийн засгийн чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах боллоцоогоор хангана. Тендерт оролцогчдыг менежментийн гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах боллоцоогоор хангана.

Тендерийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр шалгаруулна:

1. Эдийн засгийн чөлөөт бүсэд болон тухайн бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн үр чадвар;

(0-30 оноо)

2. Санал болгож байгаа бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, түүнд Засгийн газраас дэвшүүлсэн зорилтыг хүлээн авч тусгасан байдал;

(0-25 оноо)

3. Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт;

(0-10 оноо)

4. Хөрөнгө оруулалтын санал

(0-35 оноо)

Нийлбэр дүнгээр хамгийн өндөр, гэхдээ 85-аас доошгүй оноо авсан тендерийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна. Тендерт оролцох албан ёсны өргөдөл болон тендерийн саналуудыг дараахь хаягаар ирүүлнэ үү.

Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг  
Танаа

Үйлдвэр, худалдааны яам  
Засгийн газрын П байр, А корпус  
210646 Улаанбаатар хот, Монгол Улс  
Утас: 976-11-327912  
Факс: 976-11-327914

Засгийн газрын 2004 оны 36 дугаар  
тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

## УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ(ТЕНДЕР)-ЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний (казино оролцуулан) гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад энэ уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

2. Үйлдвэр, худалдааны яам нь уралдаант шалгаруулалт (тендер)-ын комисс томилон зөвлөхүүдийн туслацлаатайгаар тендерийг зохион байгуулна.

### Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1. "Эдийн засгийн чөлөөт бүс" гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлал-үйлчилгээний цогцолбор бүхий хэлбэрийг хосолсон хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.

2.2. "Стратегийн хөрөнгө оруулагч" гэж эдийн засгийн чөлөөт бүсийн менежментийн арга барил эзэмшсэн, чөлөөт бүсэд тухайн бизнесийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, 150 (нэг зуун тавин) сая ам.доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй, санхүүгийн тогтвортой байдалтай, үйл ажиллагааны туршлагатай /үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/ компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциумыг хэлнэ.

2.3. "Ерөнхий мэдээлэл" гэж тендерт оролцогч бүрт хүргэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаархи мэдээллийн баримт бичгийг хэлнэ.

2.4. "Дэнчин" гэж хөрөнгө оруулалт, менежментийн гэрээг байгуулах амлалт, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болон тендерт оролцогчоос төлөх 500000 /таван зуун мянган/ ам.доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Дэнчинг Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны валютын дансанд төлнө.

2.5. "Зөвлөх" гэж эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлаар мэргэшсэн, олон улсын тендер зарлах, сонгон шалгаруулах арга барил, туршлага хуримтлуулсан зөвлөх эрхтэй, Үйлдвэр, худалдааны яамнаас томилсон хувь хүн эсхүл хуулийн этгээдийг хэлнэ.

2.6. "Нууцыг хадгалах тухай гэрээ" гэж Монгол Улсын Засгийн газар, Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүдээс өгөх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүстэй холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.7. "Өргөдөл" гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх өргөдөл, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын иж бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг бичгээр үйлдэж, өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргагч тендерт оролцохын тулд урьдчилан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаархи мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

2.8. "Тендерийн баримт бичиг" гэдэгт:

1/Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам;

2/Ерөнхий мэдээлэл;

3/Менежментийн гэрээний төслийн иж бүрдлийг тус тус ойлгоно.

2.9. "Тендерт оролцогч" гэж тендерт оролцохоор өргөдөл гаргасан, урьдчилан шалгаруулалтын шатанд Үйлдвэр, худалдааны яам өргөдлийг нь хүлээн авч шалгаруулсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

2.10. "Тендерийн санал" гэж тендерт оролцогчоос тендерт оролцохоор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн саналд үр ашигтай, бодит хөрөнгө оруулалтын хэмжээ тодорхой тусгагдсан байна.

2.11. "Тендерийн хураамж" гэж тендерийн баримт бичгээр хангах үйлчилгээний хураамж болгон тендерт оролцогч Үйлдвэр, худалдааны яаманд төлөх 1000 /нэг мянган/ ам.долларын буцааж төлөгдөхгүй төлбөрийг хэлнэ.

2.12. "Уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/ гэж тендерт оролцогчдоос ирүүлсэн

тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй менежментийн гэрээ байгуулах үйл ажиллагааг хэлнэ.

2.13. "Менежментийн гэрээний төсөл" гэж Үйлдвэр, худалдааны яамнаас санал болгож байгаа, тендэрт оролцогчдод тэдний саналыг авахаар хүргүүлэх менежментийн гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.14. "Менежментийн гэрээний шинэчилсэн төсөл" гэж менежментийн гэрээний төслийн эхний хувилбарт тендэрт оролцогчдын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.15. "Менежментийн гэрээний эцсийн төсөл" гэж менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд тендэрт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Үйлдвэр, худалдааны яамнаас эцэслэн бэлтгэсэн төслийг хэлнэ.

2.16. "Хөрөнгө оруулалтын хэмжээ" гэж "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг барьж байгуулан санхүүжүүлэхэд зориулах тендэрт оролцогчоос санал болгож байгаа хамгийн оновчтой, бодит хөрөнгө оруулалтын хэмжээ (үнийн дүн)-г хэлнэ.

## Гурав. Тендерийн хуваарь

3.1. Тендерийг энэхүү журамд хэвсэргэсэн хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.

## Дөрөв. Тендэрт оролцогч

4.1. Тендэрт оролцогчийн эрх зүйн байдал

4.1.1. Урьдчилан шалгаруулалтад тэнцсэн компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциум зэрэг тодорхой хэмжээнд шаардлага хангасан бүх боломжит хөрөнгө оруулагчид тендэрт оролцож болно.

4.1.2. Тендэрт оролцогч тендэрт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.3. Тендэрт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа тохиолдолд тэд зөвхөн нэг /1/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендэрт нэг оролцогч болж оролцоно.

4.2. Тендэрт оролцогчийн эрх

4.2.1. Тендэрт оролцогч нь тендэрт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд Үйлдвэр, худалдааны яамнаас

баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгийг иж бүрэн нэг багцыг авах эрхтэй байна.

4.2.2. Тендэрт оролцогч нь дараахь эрх эдэлнэ:

1/Мэдээллийн танхимд тавигдсан мэдээллийг ашиглах;

2/Үйлдвэр, худалдааны яамнаас баталсан хуваарийн дагуу "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүстэй танилцах, дүн шинжилгээ болон уулзалт хийх, чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх;

3/Үйлдвэр, худалдааны яамнаас бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтантай уулзах;

4/Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар, тодруулга авах зорилгоор чөлөөт бүсийг хариуцсан Үйлдвэр, худалдааны яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах.

Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж Үйлдвэр, худалдааны яаманд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ.

Үйлдвэр, худалдааны сайд

Ч.Ганзориг Танаа

Үйлдвэр, худалдааны яам

Засгийн газрын П байр, А корпус

210646 Улаанбаатар хот, Монгол

Улс

Утас: 976-11-327912

Факс: 976-11-327914

Үйлдвэр, худалдааны яам ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариу өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендэрт оролцогч бүрт тэдгээрийн өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат захиа, факс, эсхүл электрон шууданг ашиглаж болно.

Тендерийн санал авах хугацаа дуусахаас ажлын

5 /тав/-аас доош өдөрт ирүүлсэн тайлбар, тодруулга авах хүсэлтийг Үйлдвэр, худалдааны яам хүлээж авахгүй байж болно.

5/Монгол Улсын хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

4.3. Тендэрт оролцогчийн үүрэг

Тендэрт оролцогч нь дараахь үүрэгтэй:

4.3.1. Өөрийн бизнес, эрх зүйн болон санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх.

4.3.2. Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүйн болон санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Үйлдвэр, худалдааны яаманд нэн даруй мэдээлэх.

4.3.3. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо болон хэлэлцээрийн аливаа хэлбэрт орохгүй байх.

4.3.4. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулах асуудлаар банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Үйлдвэр, худалдааны яаманд бичгээр мэдэгдэх.

4.3.5. Тендерт оролцох буюу оролцохтой холбоогон гарах бүх зардлыг өөрөө хариуцах.

4.3.6. Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

## Тав. Тендерийн баримт бичиг

5.1. Тендерт оролцогч тус бүрт тендерийн журам, ерөнхий мэдээлэл, менежментийн гэрээний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгийн нэг иж бүрдлийг олгоно.

5.2. Үйлдвэр, худалдааны яамнаас олгох тендерийн баримт бичигт Үйлдвэр, худалдааны яамны тэмдэг дэрсэн байна.

5.3. Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулна. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

## Зургаа. Дүн шинжилгээ хийх

6.1. Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана.

6.2. Тендерт оролцогчдыг тендерийн саналаа ирүүлэхээс нь өмнө эдийн засгийн чөлөөт бүс дээр очиж дэд бүтэц, хөрөнгө оруулалтын нөхцөлийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтын талаар Үйлдвэр, худалдааны яамны холбогдох албан тушаалтан болон зөвлөхүүдтэй санал солилцох бололцоогоор хангана. Үйлдвэр, худалдааны яам тендерт оролцогч тус бүрт эдийн засгийн чөлөөт бүс дээр очиж нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зориулж ойролцоогоор 1 /нэг/

долоо хоногийн хугацаа олгоно. Оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд Үйлдвэр, худалдааны яам өөрийн үзэмжээр нэмэлт хугацаа олгож болно. Дүн шинжилгээ хийх хугацаанд тендерт оролцогчид чөлөөт бүсийн удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдана.

6.3. Үйлдвэр, худалдааны яам нь чөлөөт бүс дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дарааллаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4. Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр чөлөөт бүсийн нөхцөл байдлыг судлан зөвшөөрч, эдгээр нөхцөл байдал болон Үйлдвэр, худалдааны яамнаас гаргаж өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдлаар танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, менежментийн гэрээний төслийг боловсруулах үүргээс чөлөөлөгдөхгүй. Үйлдвэр, худалдааны яам, зөвлөх, чөлөөт бүсийн холбогдох ажилтнуудаас гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Үйлдвэр, худалдааны яам, зөвлөх, шинжээчдийн баг, чөлөөт бүсийн холбогдох ажилтнуудын аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5. Тендерт оролцогч дүн шинжилгээ хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

## Долоо. Менежментийн гэрээний төслийг эцэслэн боловсруулах

7.1. Тендерт оролцогчдоос 2004 оны 4 дүгээр сарын 7-ны дотор Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулна.

7.2. Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2004 оны 4 дүгээр сарын 9-ний дотор хүргүүлнэ.

7.3. Менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2004 оны 4 дүгээр сарын 12-ны дотор ирүүлэхийг тендерт оролцогчдод санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4. Менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2004 оны 4 дүгээр сарын 14-ний дотор хүргүүлнэ.

Найм, Тендерийн санал бэлтгэх, санал ирүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

Дансны нэр : Үйлдвэр, худалдааны яам 3309001  
 Дансны дугаар : Харилцагч банк : Federal Reserve Bank of New York, NY, USA  
 SWIFT код : FRNYUS33  
 Дансны нэр : Монгол банк  
 Дансны дугаар : 021088506

8.1. Бүх мөнгөн дунг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2. Тендерт оролцогчид тендерийн саналыг англи эсхүл монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлнэ. Харин менежментийн гэрээний эцсийн хувилбарыг англи, монгол хэл дээр ирүүлнэ.

8.3. Тендерт оролцогчид тендерийн саналын нэг /1/ эх хувь болон таван /5/ хуулбарыг ирүүлнэ.

8.4. Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.5. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналд гарын үсэг зурж, хуудас бүрт хар буюу хөх өнгийн бэхээр нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг бичгээр гаргаж, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6. Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу эсхүл нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна.

8.7. Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Үйлдвэр, худалдааны яаманд дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8. Үйлдвэр, худалдааны яам тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дугтуйн дээрх хаягаар юуу тендерт оролцогчийн Үйлдвэр, худалдааны яамны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9. Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсхүл татан авах эрхтэй.

Ес. Дэнчин

9.1. Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид Үйлдвэр, худалдааны яамны дор дурдсан валютын харилцах дансанд 500000 /таван зуун мянган/ америк долларын дэнчин төлнө.

Үүнд:

Банкны нэр : Монгол Улсын "Монголбанк"  
 SWIFT код : BOMUMNUB

Дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг тендерийн саналд хавсаргана.

9.2. Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3. Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг үйл ажиллагаагаа эхэлсний дараа түүний хүсэлтийн дагуу ажлын 7 (долоо) өдөрт багтаан Монгол Улсын аль нэг арилжааны банкинд нээсэн валютын харилцах дансанд нь шилжүүлнэ.

9.4. Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоо/ өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5. Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1/ялагч нь тендерийн саналтайгаа хамт англи, монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан менежментийн гэрээний эцсийн хувилбарыг ирүүлээгүй буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан;

2/ялагч нь менежментийн гэрээний нөхцөл, болзлыг болон гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгаа, тохиролцоогоо материаллаг байдлаар зөрсөн.

9.6. Дэнчинд хүү төлөхгүй.

9.7. Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

Арав. Тендерийн санал бэлтгэн ирүүлэх

10.1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид дараахь нөхцөлийг хангах шаардлагатай.

10.1.1. Засгийн газраас дэвшүүлсэн дор дурдсан зорилтыг тусгасан бизнесийн стратеги

болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх. Үүнд:

1/ "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орчин үеийн чөлөөт бүсийн жишигт хүргэж, Монгол Улсын төвийг бүсийг хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүтэц бүс болгоход хувь нэмэр оруулах замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд нөлөөлөх;

2/ дэхийн өндөр хөгжилтэй үйлдвэрлэл, технологийн чиглэлээр тэргүүлэгч орнуудтай худалдаа, ялалт жуулчлалын болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орос, хятадын хоёр том зах зээлийг холбосон худалдааны томоохон гүүр болгох, улмаар Зүүн Өмнөд азийн орнуудын зах зээлд нэвтрэх гол гарцын нэг болгох;

3/ экспорт, импортын зохистой харьцааг хадгалах, гадаад худалдааг үр ашигтай хөгжүүлэх боломжийг брдүүлэх замаар улс орны зах зээлийн хангамж нийүүлэлтийг сайжруулах.

10.1.2. Бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны стратегийн хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж ирүүлэх.

10.2 Тендерийн саналд бизнес төлөвлөгөөний үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалтын хэмжээ, эзэгжүүлэх хугацаа маш тодорхой тусгасан байна.

10.3 Тендерийн саналын эх хувь болон хуулбаруудыг "ТЕНДЕРИЙН САНАЛ", "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дугуйлна. Эдгээр дугуйг өөр дугуйд давхар хийж битүүмжлэнэ. Гаднах дугуй дээр Үйлдвэр, худалдааны яамны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН  
УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ/ТЕНДЕР/Т  
ОРОЛЦОХ НУУЦ САНАЛ-ТЕНДЕРИЙН  
САНАЛ"

"ШИНЖЭЭЧДИЙН БАГИЙГ  
БАЙЛЦУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ  
ХОРИГЛОНО"  
гэсэн тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Үйлдвэр, худалдааны яамны дотоо хаягаар 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө ирүүлнэ.

Үйлдвэр, худалдааны сайд  
Ч.Гэнзориг Танаа

Үйлдвэр, худалдааны яам  
Засгийн газрын П байр, А корпус

210546 Улаанбаатар хот, Монгол  
Улс

Утас: 976-11-327912

Факс: 976-11-327914

#### 10.4. Тендерийн санал

Тендерийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

A. Тендерт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

- (1) Тендерт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй банк болон компани тус бүрээр гаргаж өгнө);
- (2) Сүүлийн гурван /3/ жилийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (нээлтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан сүүлийн 3 жилийн тайлан);
- (3) Тендерт оролцогчийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж байгаа хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн жагсаалт (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч байгаа компани тус бүрийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж байгаа хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг энэхүү жагсаалтад оруулна);
- (4) Тендерт оролцогчоос санал болгож байгаа тендерт холбогдолтой байж болох бусад нэмэлт мэдээлэл.

B. Бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө

Бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд эдийн засгийн чөлөөт бүсийг цаашид хөгжүүлэх бизнесийн стратегийг тодорхойлно. Тав (5)-аас доошгүй жилийг хамарсан энэхүү төлөвлөгөөнд дор дурдсан арга хэмжээг тусгасан байвал зохино. Үүнд:

(1) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг олон улсын жишигт нийцсэн чөлөөт бүс болгон барьж байгуулахад хөрөнгө оруулалт хийх талаар санал болгож байгаа ерөнхий стратегийн зорилго;

(2) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд бий болгож хөгжүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагааны хөгжил;

(3) Төлөвлөж байгаа санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, таван жилийн санхүүгийн прогноз;

(4) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламж болон үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний хэсгийг барьж байгуулах, хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, өртөг зардлын бүтэц;

(5) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон мастер төлөвлөгөө;

(6) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн ажилтан, албан хаагчдыг сургах сургалтын хөтөлбөр, удирдлага зохион байгуулалтын хөгжил, гадаадын удирдлагын бүрэлдэхүүн, тоо, албан тушаал зэргийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө;

(7) Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт.

## В. Дэнчин төлснийг нотлох баримт

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендер оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөж, түүнд тусгасан бүх нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендер оролцохыг зөвшөөрч тухайн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас тендер оролцохыг зөвшөөрч гаргасан шийдвэр).

## 10.5. Менежментийн гэрээ

А. Тендер оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зохих журмын дагуу гарын үсэг зурсан менежментийн гэрээний эцсийн төслийн англи болон монгол хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь. Менежментийн гэрээний эцсийн хувилбарын гарын үсэг зурсан хоёр эх хувийг тендерийн саналын эх хувьд хавсаргасан байх шаардлагатай. Тендер оролцогчоор бөглүүлэхээр зориуд хоосон үлдээсэн хэсгийг бөгөөд өөрөөр менежментийн гэрээний эцсийн хувилбарт өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

Менежментийн гэрээний эцсийн хувилбарт дараах зүйлийг хавсаргана:

(1) Менежментийн гэрээний эцсийн хувилбарт гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагын шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч байгаа хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр);

(2) Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэг:

Гэрээнд гарын үсэг зурах

Тендерийн саналыг нэхж ажиллагаанд тендер оролцогчийг төлөөлөх.

Тендер оролцогчийн өргөдөл хавсаргасан итгэмжлэгд эдгэр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

## Арван нэг. Снхүүгийн анал

11.1. Үйлдвэр, худалдааны ям тендерийн саналыг үнэлүүлэх зорилгоор шэнжээдийн багийг томилно.

11.2. Шинжээчдийн баг нь тендерийн саналыг дор дурдсан шалгаруулах үзлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ Үүнд:

- (1) Эдийн засгийн чөлөөт үсэд болон тухайн бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэ туршлага, санхүүгийн чадагхи, иэр хүнд, бизнесийн ур чадвар (0-3 оноо);
- (2) Санал болгож байгаа бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, түүнд Засгийн газраас дэвшүүлсэн зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-2 оноо);
- (3) Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт (0-10 оноо);
- (4) Хөрөнгө оруулалтын санал (0-35 оноо).

Нийлбэр дүнгээр хамгийн өндөр гхдээ 85-аас доошгүй оноо авсан тендерийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шагаруулна.

11.3. Тендерийн саналыг тендер оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан нийтийн өмнө тендерин хуваарт заасны дагуу 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр тендерийн комисс задална.

11.4. Тендер оролцогчийн нэр болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд оруулах хөрөнгө оруулалтын нийт хэмжээг чанар уншиж, бүртгэнэ. Шинжээчдийн баг тендерийн санал болгонд менежментийн гэрээний эцсийн төслийг хавсаргаж, зохих журмын дагуу гарын үсэг зурсан эсэхийг шалгах бөгөөд тендерийн аналүүдийг нийтийн өмнө задалж ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.



11.5. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагааг ажлын 3 (гурав) өдөрт дуусгасны дараа шинжээчдийн баг нь тендерийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.6. Тендерийн саналын үнэлгээний тайлан гаргасан өдрөө шинжээчдийн баг нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-ийн төслийг бэлтгэж, Үйлдвэр, худалдааны яамны тендерийн комиссоор хянуулан батлуулна.

11.7. Хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогч ижил оноо авсан тохиолдолд тэдгээрийг энэхүү журмын нэгдүгээр үзүүлэлтийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв энэ саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцэж байвал хөрөнгө оруулалтын шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч бусдаасаа илүү оноочтой хөрөнгө оруулалтын санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.8. Үйлдвэр, худалдааны яам тендерт ялагчаар шалгараагүй оролцогчдод энэ тухай болон дэнийг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.9. Шинжээчдийн баг болон Үйлдвэр, худалдааны яамны тендерийн комиссын гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Үйлдвэр, худалдааны сайд гарын үсэг зурсан

тендерийн нэгдсэн мэдэгдэл /тэмдэглэл/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.10. Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахыг урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг Үйлдвэр, худалдааны сайд хуудас бүр дээр гарын үсэг зурсан менежментийн гэрээний эх хувьтай хамт олгоно.

Арван хоёр. Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох өргөдөл, саналируулах хугацаа

12.1. Үйлдвэр, худалдааны яам өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн санаачилгаар эсхүл тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сонгах буюу тендерийн хугацааг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2. Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Үйлдвэр, худалдааны яам бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

Тендерт оролцогчийн гарын үсэг.....  
он, сар, өдөр.....

### Тендерийн журмын хавсралт

Агуулга	Огноо/эцсийн хугацаа
Тендерийн зар мэдээ	2004.2.25
Өргөдлөө ирүүлэх	2004.3.1-2004.3.25
Урьдчилсан шалгаруулалт /тендерийн баримт бичгийг хүргүүлэх	2004.3.10-2004.4.1
Оролцогчид газар дээр нь танилцах, судалгаа хийх санал, дүгнэлт гаргах хугацаа	2004.3.10-2004.4.1
Менежментийн гэрээний төсөлд санал авах	2004.4.7
Менежментийн гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, хүргүүлэх	2004.4.9
Менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал авах	2004.4.12
Менежментийн гэрээний төслийг эцэслэн боловсруулж дуусган тендерт оролцогчдод хүргүүлэх	2004.4.14
Тендерийн санал хүлээн авах /эцсийн хугацаа/	2004.4.26
Тендерийн саналын үнэлгээ	2004.4.26-2004.4.27
Тендерийн үр дүн, ялагчийг зарлах	2004.4.28
Гэрээнд гарын үсэг зурах	2004.4.28

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 37

Улаанбагаас хот

### Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Дорноговь аймгийн зарим сумдын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Айраг сумын нутаг дэвсгэрт 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хорио цээрийн онцгой дэглэм тогтоон нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Дорноговь аймгийн Сайншанд, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Эрдэнэ, Сайхандулаан, Улаанбадрах, Замын-Үүд; Говьсүмбэр аймгийн Шивээ-Овоо, Сүмбэр, Баянтал; Хэнтий аймгийн Галшар, Дархан, Дундговь аймгийн Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. Дорноговь аймгийн Засаг дарга Ж.Батсуурьт даалгах нь:

а/гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн сумдад хорио цээрийн онцгой дэглэмийг чанд мөрдүүлэх замаар шүлхий өвчний тархалтыг таслан зогсоох, сэргийлэх, голомтыг устгахад чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;

б/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт иргэд, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, малын шилжилт, хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ авсугай;

в/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутагт орох, гарах гол зам дээр шалган нэвтрүүлэх пост, ариутгал, халдваргүйжүүлэлтийн цэгүүдийг зохих заавар, журмын дагуу байгуулан ажиллуулсугай;

г/шүлхий өвчний ил шинж тэмдэг илэрсэн мал, амьтан, бохирдсон бүтээгдэхүүн, түүхий эдийг устгах, халдварын голомтод ариутгал,

халдваргүйжүүлэлт хийх арга хэмжээг зохих журмын дагуу шуурхай хэрэгжүүлсүгэй;

д/мал сүргийг байнгын хариуца маллагаатай болгон эмнэл зүйн үзлэгийг 2004 оны 2 дугаар сарын 18-ны дотор хийж өвчний сэжиг илэрсэн тохиолдолд шуурхай штабт мэдээлж халдвар тархахаас хамгаалах арга хэмжээг тусгай бүр авсугай;

е/гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлсэн нутаг дэвсгэрт уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээний тусгай мэдээллийг иргэдэд хүргэн таниулах ажлыг зохион байгуулсугай;

ж/хорио цээрийн онцгой бөгөн хязгаарлалтын дэглэм тогтоосон сум, багийн холбоо 24 цагийн ажиллагаанд оруулж, шуурхай штабтай байнгын холбоотой ажиллуулах арга хэмжээ авсугай.

4. Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Дундговь аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан хязгаарлалтын дэглэм тогтоосон сумдын нутаг дэвсгэрт хорио цээрийн зохих дэглэмийг мөрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажилласугай;

б/мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийг үндэслэн хязгаарлалтын дэглэм бүхий нутгийн зааг, уг бүсэд орох, түүнээс гарах, дамжин өнгөрөх цэг, зурвасыг нарийвчлан тогтоож, анхааруулсан тэмдэг, дохио, санамж тавиулах, харуул хамгаалалт гарган ажиллуулах, иргэд, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, журамлах арга хэмжээ авсугай;

в/гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2004 оны 2 дугаар сарын 17-ны дотор тодотгол хийж, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авсугай;

г/малын гоц халдварт өвчин гарсан үед шуурхай штаб дэлгэх, шаардагдах эм, ариутгалын бодисыг нөөцлөх, ажиллах хүч, хэрэгслийг томилгоожуулах ажлыг зохион байгуулсугай.

5. Нийслэл, аймгийн төв болон экспортод бүтээгдэхүүн нийлүүлдэг суурин газрын шүлхийгээр өвчлөмтгий мал, гэрийн тэжээвэр амьтныг вакцинжуулан, мал эмнэлэг, ариун цэвэр, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах, хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгахыг Дорнод, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Төв аймаг болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасуяй.

6. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжсэн аймгуудад шүлхий өвчинтэй тэмцэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, холбогдох арга хэмжээг иж бүрнээр авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ цагийн байдлын талаар Засгийн газарт тогтмол мэдээлж байхыг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид даалгасуяй.

7. Шүлхий өвчинтэй тэмцэх мэргэжил, арга зүйн удирдлага, шаардагдах вакцин, зуу, тариураар хангаж ажиллах, оношилгоог баталгаажуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасуяй.

8. Шүлхий өвчнөөр өвчлөмтгий ан амьтны байршил, хөдөлгөөнд тандалт хийж, өвчний сэжиг илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасуяй.

9. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлсэн аймаг, сумдад хорио цээрийн дэглэмийг чандлан сахиулж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн чанар, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатарт даалгасуяй.

10. Шүлхий өвчний тархалтаас сэргийлэх арга хэмжээ болон вакцинжуулалтад шаардагдах хөрөнгийн эхний ээлжийн 1760.5 (нэг тэрбум долоон зуун жаран сая таван мянган) сая төгрөгийн 1300.0 (нэг тэрбум гурван зуун сая) сая төгрөгийг улсын төсвөөс, 460.5 (дөрвөн зуун жаран сая таван зуун мянган) сая төгрөгийг эрсдэлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

11. Халдварын голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй холбогдуулан шүлхийн вакцин, оношлуурыг шуурхай нийлүүлэх болон шуурхай штабын зардлын тооцоог хянан шийдвэрлүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал,

Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт даалгасуяй.

12. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгах нь:

а/хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрээ дамжин өнгөрч байгаа улсын чанартай авто болон төмөр замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтад авч, шалган нэвтрүүлэх пост, халдварын голомт бүхий бүс нутгаас гарах зорчигч, авто тээврийн хэрэгслийг шуурхай штабын зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай баримтыг үндэслэн нэвтрүүлж байх арга хэмжээ авсугай;

б/ хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутагт нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсугай.

13. Хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт харуул хамгаалалт гаргах, өвчтэй мал, зээрийг устгах, үхсэн мал, амьтны сэг, зэмийг зааврын дагуу булшлах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор зэвсэгт хүчнээс шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг гарган ажиллуулах асуудлаар санал боловсруулж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.9-д заасны дагуу Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид тавьж шийдвэрлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад даалгасуяй.

14. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хүний эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, эм, бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх, хүн амыг мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад даалгасуяй.

15. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын хөдөлгөөнд зохицуулалт хийж Дорноговь аймгийн Айраг, Өргөн, Эрдэнэ сумын төмөр замын өртөө, Айраг-Сайншандын хоорондох зөрлөгүүдэд зорчигч буулгах, суулгахыг хориглох, Сайншанд өртөөнөөс зөвхөн ариутгал, халдваргүйжүүлэлтэд хамрагдсан зорчигчийг суулгах, Замын-Үүд-Улаанбаатар, Сайншанд-Улаанбаатарын чиглэлийн суудлын галт тэргээр зорчигчдыг ариутгах цэгийг нийслэлээс Замын-Үүд хүртэлх төмөр замын буудлуудад байгуулан ажиллуулах арга хэмжээ авахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

16. Малын гоц халдварт өвчний гарсан шалтгааныг тогтоох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайхан нарт даалгасугай.

телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

17. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын явц, үр дүнгийн талаар иргэдийг бодит мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангаж ажиллахыг Радио,

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД** **Д.НАСАНЖАРГАЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 2 дугаар  
сарын 18-ны өдөр**

**Дугаар 38**

**Улаанбаатар  
хот**

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

анхдугаар хуралдаанд оролцох Монголын талын төлөөлөгчдийн зардалд зориулан 20.9 (хорин сая есөн зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2004 оны 2 дугаар сарын 25-27-нд Астана хотноо зохион байгуулагдах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын Комиссын Ш хуралдаан, 2004 оны 3 дугаар сарын 1-3-нд Бишкек хотноо зохион байгуулагдах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын Комиссын

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

**САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД** **Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 2 дугаар  
сарын 18-ны өдөр**

**Дугаар 39**

**Улаанбаатар  
хот**

**Тогтоолд нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"хилийн цэргийнх ногоон" гэсний дараа "дотоодын цэргийнх хүрэн улаан" гэж тус тус нэмсүгэй.

"Дүрэмт хувцас, хэрэглэлийн нормыг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, 1 дүгээр хавсралтын гарчигийн "Зэвсэгт хүчин" гэсний дараа "дотоодын цэрэг" гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын тайлбарын 1, 5-ын

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД** **Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 2 дугаар  
сарын 18-ны өдөр**

**Дугаар 40**

**Улаанбаатар  
хот**

**Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг  
тогтоох тухай**

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт

заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:



1. 2004 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 841300 (найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун) төгрөг байхаар тогтоосугай.

2. Мөнгөн төлбөрийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт, мөнгөн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн төлүүлэх арга хэмжээг авч

байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар  
хот

### Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35.2, Малын удмын сая, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, өвчний голомтыг устгах арга хэмжээ болон шуурхай штабуудын зардалд зориулан эхний ээлжинд 145.0 (нэг зуун дөчин таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Гамшгаас хамгаалах ерөнхий газрын мэдэлд шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Дээрх хөрөнгийг хорио цээрийн дэглэм тогтоон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аймаг, шуурхай штабуудаас гаргасан тооцоо, санхүүгийн баримтыг нягтлан үзээний үндсэн дээр зориулалтын дагуу зарцуулахыг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар  
хот

### Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.6, 31.2, 31.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хорио болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталж 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журам"-ыг 5 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажил үүрэг гүйцэтгэдэг төрийн

албан хаагчийн хувьд энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан цалингийн сүлжээг "1.16" гэсэн итгэлцүүрээр өсгөн хэрэглэсүгэй.

4. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээг тухайн онд батлагдсан цалингийн сандаа багтаан хэрэгжүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерүүдэд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 195 дугаар тогтоолыг хүчингүй болгонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН  
САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2004 оны 42 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сая төгөөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	45400	48600	52700	55900	59100	63000	65800	69400	73200	77000	81100	84600	88500
2	48600	52500	57100	60700	64300	68000	71100	74500	78800	82100	90700	94000	96300
3	51800	56300	61500	65600	69400	73200	76300	79500	84400	87200	100400	102200	104100
4	55100	60200	65900	70300	74600	78300	81500	84500	89900	92200			
5	58400	64100	70300	75000	79800	83300	86600	89500	95400	97300			

Засгийн газрын 2004 оны 42 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,  
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ  
ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ,  
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО  
БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сая төгөөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	56100	59100	63000	65700	69400	73200	76900	79800	84000	88100	92400
2	61100	64300	68000	70800	74500	78500	81800	84500	92300	96100	100200
3	66000	69400	73200	76100	79400	83700	86600	89300	100600	104100	108000
4	70800	74600	78400	81300	84400	89000	91600	94100			
5	75800	79800	83300	86500	89500	94300	96500	98800			

Засгийн газрын 2004 оны 42 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(саяд тогтоогоор)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	42100	45400	48600	51800	53200	54000	57200	59100	63100	63500	64600	65700	69400	73200	75700	79700	84000	88500
2	45500	48600	52500	56200	57700	58900	62200	64300	67900	68600	69800	70900	74500	78800	81100	89500	93200	96300
3	48800	51800	56300	60600	62200	63900	67300	69400	72700	73600	74900	76100	79500	84400	86400	99500	102400	104100
4	52100	55000	60200	64900	66800	68800	72200	74600	77500	78600	80000	81400	84600	89900	91700			
5	58400	64100	69200	71400	73700	77200	79800	82200	83600	85100	86500	89500	95400	97000				

Засгийн газрын 2004 оны 42 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(саяд тогтоогоор)

Цалингийн доод жшгийн шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14				
1	40000	40400	41400	42600	43400	47000	50500	54100	57600	62100	66500	72800	79900	87000				
2	40400	41400	42600	43200	46300	50100	53600	57200	60700	65300	73200	79000	85200	94000				
3	41400	42600	44000	45700	49200	53200	56800	60300	63800	68400	79900	85100	90500	100900				
4	44000	45500	46700	48200	52100	56300	59600	63400	67000	71500								
5	46900	48400	49200	50500	55000	59400	62300	66500	70100	74500								

Засгийн газрын 2004 оны 42 дугаар  
тогтоолын 5 дугаар хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР МӨНГӨН УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ

*Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Энэхүү журмын зорилго нь Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад эрх зүйн актын хүрээнд төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил/цаашид "мөнгөн урамшил" гэх/ олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төсвийн ерөнхий менежерүүд нь энэхүү журмын дагуу төрийн албан хаагчид мөнгөн урамшил олгох арга хэмжээг тухайн онд батлагдсан цалингийн сандаа багтаан авч хэрэгжүүлнэ.

*Хоёр. Хамрах хүрээ*

2.1. Мөнгөн урамшлыг бүх шатны төрийн улс төрийн албан тушаалтан, төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтан, бүх шатны шүүгч, прокурор болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан

хаагчдаас бусад бүх ангилал, зэрэглэлийн төрийн албан хаагчдад олгоно.

2.2. Мөнгөн урамшлыг "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх журам", "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу А, В, С үнэлгээ авсан төрийн албан хаагчдад олгоно.

*Гурав. Мөнгөн урамшлын дээд хэмжээ*

3.1. Төсвийн ерөнхий менежер нь төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгохдоо дор дурдсан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

а/Төрийн жинхэнэ албан хаагчид:

№	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Ажлын үр дүнгийн үнэлгээ		
			С	В	А
			Урамшууллын дээд хэмжээ /мянган төгрөгөөр/		
1.	Туслах түшмэл	ТЗ-1 - ТЗ-3, ТТ-1 - ТТ-4	70.0	80.0	90.0
2.	Дэс түшмэл	ТЗ-4 - ТЗ-6, АА-9 - АА-11, ТТ-5 - ТТ-10	80.0	120.0	160.0
3.	Ахлах түшмэл	ТЗ-7 - ТЗ-9, АА-6 - АА-8, ТТ-11 - ТТ-14	120.0	160.0	190.0
4.	Эрхэлсэн түшмэл	ТЗ-10 - ТЗ-11, АА-4 - АА-5, ТТ-15 - ТТ-16	160.0	220.0	270.0
5.	Тэргүүн түшмэл	ТЗ-12 - ТЗ-13, АА-1 - АА-3, ТТ-17 - ТТ-18	220.0	290.0	360.0



б/Төрийн үйлчилгээний албан хаагчид

№	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Урамшууллын жишиг хэмжээ /мянган төгрөг/		
			С	В	А
1.	Бага	ТҮ-1	40.0	50.0	60.0
2.	Техникийн гүйцэтгэх ажилтан	ТҮ-2 - ТҮ-4	50.0	70.0	90.0
3.	Мэргэжлийн албан хаагч	ТҮ-5 - ТҮ-7	70.0	100.0	120.0
4.	Удирдах албан хаагч	ТҮ-8 - ТҮ-14	100.0	150.0	200.0

Дөрөв. Мөнгөн урамшлыг олгох

Тав. Бусад зүйл

4.1. Төсвийн ерөнхий менежер нь дараа оны 2 дугаар сарын 15-наас өмнө төрийн албан хаагчийн ажлын үр дүнг зохих журмын дагуу үнэлнэ.

4.2. Ерөнхий менежер төрийн албан хаагчийн жилийн ажлын үр дүнгийн үнэлгээ /А, В, С/-г үндэслэн энэхүү журмын 3.1-д заасан хэмжээнд багтаан мөнгөн урамшлын хэмжээг тогтоон тухайн төрийн албан хаагчид мэдэгдэнэ.

4.3. Төсвийн ерөнхий менежерт мөнгөн урамшил олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч гаргана.

5.1. Төсвийн ерөнхий менежерийн мөнгөн урамшил олгох шийдвэр, түүнийг төрийн албан хаагч хүлээн зөвшөөрсөн тухай мэдээллийг байгууллага нь албан хаагч бүрээр дараахь хүснэгтийн дагуу гаргаж тухайн оны 2 дугаар сарын 25-ны дотор багтаан төсвийн ерөнхийлөн захирагчаар дэмжуулан Төрийн албаны зөвлөлд ирүүлж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн мэдээллийг үндэслэн мөнгөн урамшилд шаардагдах хөрөнгийг Санхүү, эдийн засгийн яам болон холбогдох төв, орон нутгийн санхүүгийн байгууллага санхүүжүүлнэ.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МӨНГӨН УРАМШУУЛЛЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

Нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Төрийн албанд ажилласан жил	Тухайн үеийн цалин хөлс /мян. төг/ Үүнээс		Үнэлгээ	Урамшлын хэмжээ /мян. төг/	Тайлбар
			Үндсэн цалин	Нэмэгдэл, нэмэгдэл хөлс			
Дүн							

5.2. Энэхүү журмын 5.1-д дурдсан мэдээлэлд Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн

засгийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3